

С. Хүний эрхийн байгууллагууд

15. Хариуцаж буй асуудлынхаа цар хүрээ, түвшин болон чиг үүргээсээ шалтгаалан Монгол Улсын яамдууд өөр хоорондоо харилцан адилгүй байдлаар хүний эрхийг хамгаалах буюу хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам (цаашид "ХЗДХЯ" гэх) хүний эрхийн хамгааллын бодлогын үндсийг тодорхойлж, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоодог бол Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хөдөлмөрлөх эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ба бусад нийгмийн хамгааллын салбарт хамаарах эрх, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам сурч боловсрох эрх, Эрүүл мэндийн яам эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг тус тус хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Эдгээрээс гадна Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд хүний аливаа нэг эрхээр дагнан ажилладаг бөгөөд энд Хүүхдийн төлөө газар болон Жендерийн тэгш байдлын үндэсний хороо зэргийг нэрлэж болно.

16. Ийнхүү Монгол Улсад хүний эрхийг хангах асуудалд нэгдмэл хандлагаар хандах, төрийн байгууллагуудын энэ чиглэлээрх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан орон тооны бус Үндэсний хороог байгуулсан бөгөөд уг хорооны ажлын албыг ХЗДХЯ-ны бүтцэд байгуулан ажиллуулж байна. Хорооны дүрмийн дагуу яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон тооны бус салбар хороо байгуулж, нийтдээ 412 салбар хороотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

17. Засгийн газраас хараат бус, бие даасан бүтэц болох ХЭҮК-н тухай хуулийг 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр УИХ-аас баталсан бөгөөд 2001 оны 2 дугаар сараас эхлэн ХЭҮК үйл ажиллагаагаа явуулж байна. ХЭҮК нь Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцид туссан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх явдалд хяналт тавих, зөрчигдсэн эрхийг сэргээх, мөн энэ талаар санал гаргах, зөвлөмж боловсруулж төрийн байгууллагуудад хүргүүлэх зэрэг хуульд заасан онцгой эрхүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр эрхүүд нь онц байдлын үед ч хэрэгждэг.